



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 6 сарын 13 өдөр

Дугаар 336

Улаанбаатар хот

Маягт, заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийн 27.6.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын бохирдлын төлбөрийн тайлангийн маягт /ТТ-24(1)-ТТ-24(4)-ыг 1 дүгээр, тайлангийн маягтыг нөхөх зааврыг 2 дугаар, Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тайлангийн маягт /ХТТ-04/-ыг 3 дугаар, тайлангийн маягтыг нөхөх зааврыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан маягт, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Улсын төсвийн орлого, хяналтын газар, нийслэл, аймаг, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нарт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тайлангийн маягтыг программчлах ажлыг зохион байгуулахыг Татварын удирдлага, хамтын ажиллагааны хэлтэс /Б.Эрдэнэбаатар/, Татвар төлөгчтэй харилцах хэлтэс /Д.Баяраа/, Мэдээлэл статистикийн хэлтэс /Г.Батсайхан/, Мэдээлэл технологийн төв /Н.Нямдорж/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2001 оны 200 дугаар тушаалын 2-р хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БАТТӨМӨР



Үндэсний татварын алба

Маягт ТТ-24(1)

УХА0019

Агаарын бохирдлын төлбөрийн тайлан (Олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах төлбөр)

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

ТТД: _____

Тайланг хугацаа: _____ он _____ улирал

Зөвхөн татварын албан ажлын хэргэнд
БТД: _____
Татварын байцаагч: _____
Тэмдэг
Хүлээн авсан он, сар, өдөр: _____

/мянган төгрөгөөр/

Төлбөр ногдуулах биет нэгж	Мөр	Татвар төлөгчийн тодорхойлсон	Татварын алба хүлээн авсан
1. Олборлосон түүхий нүүрсний хэмжээ /тонноор/	1		
2. Олборлосон түүхий нүүрсэнд ногдуулсан төлбөрийн дүн (мөр 1*1000 кг*1 төгрөг/1000)	2		
3. Чөлөөлөгдөх төлбөрийн дүн (мөр 4*1000 кг*1 төгрөг/1000)	3		
3.1 Төлбөрөөс чөлөөлөгдөх боловсруулсан нүүрс /тонноор/ Хуулийн 8.1 дэх заалт	4		
4. Түүхий нүүрсэнд ногдуулсан төлбөрийн дүн (мөр 2-3)	5		
5. Хуулийн 8.5 дахь заалтын дагуу чөлөөлөгдөх, хөнгөлөгдөх төлбөрийн дүн /ЗГ-ын-р тогтоол/	6		
6. Төлбөл зохих төлбөрийн дүн (мөр 5-6)	7		

Татварын тооцоолол:

		Дебет	Кредит
Тайлангийн эхний үлдэгдэл	илүү	8	
	дутуу	9	
Тайланг хугацаанд ногдуулсан төлбөр (мөр 7)		10	
Тайланг хугацаанд дансаар төлсөн	Гүйцэтгэл	11	
	Өөрчлөлт /+,-/	12	
Татварын алба болон татвар төлөгч хоорондын тооцоогоор төлсөн		13	
Бусад татварын илүү төлөлтөөс суутган тооцсон		14	
Буцаан олгосон болон хүчингүй болгосон төлбөр		15	
Илүү төлөлтөөс бусад татварын өрөнд суутган тооцсон		16	
Тайлангийн эцсийн үлдэгдэл	илүү	17	
	дутуу	18	

Тайлан гаргасан:

Тайланг хүлээн авсан:

Дарга /Захирал/ /
тэмдэг

Татварын улсын байцаагч /
тэмдэг

Ерөнхий нягтлан бодогч /
тэмдэг

20 ... оны ... сарын ... –ны өдөр

Төлбөрийн тооцоолол:

			Дебет	Кредит
Тайлангийн эхний үлдэгдэл	илүү	18		
	дутуу	19		
Тайланг хугацаанд ногдуулсан төлбөр (мөр 17)			20	
Тайланг хугацаанд дансаар төлсөн	Гүйцэтгэл	21		
	Өөрчлөлт /+,-/	22		
Татварын алба болон татвар төлөгч хоорондын тооцоогоор төлсөн			23	
Бусад татварын илүү төлөлтөөс суутган тооцсон			24	
Буцаан олгосон болон хүчингүй болгосон төлбөр			25	
Илүү төлөлтөөс бусад татварын өрөнд суутган тооцсон			26	
Тайлангийн эцсийн үлдэгдэл	илүү	27		
	дутуу	28		

Тайлан гаргасан:

Тайланг хүлээн авсан:

Дарга /Захирал/
тэмдэг

Татварын улсын байцаагч
тэмдэг

Ерөнхий нягтлан бодогч
тэмдэг

20.... оны ... сарын ... –ны өдөр

4. Чөлөөлөгдөх төлбөрийн дүн /мөр 27+28+29/	26		
4.1 Мөр 23*1800 төг	27		
4.2 Мөр 24*2100 төг	28		
4.3 Мөр 25*хуулийн 7.3-д заасан А-Е ангиллын холбогдох төлбөрийн дүн	29		
5. АТБӨЯХ-д ногдуулсан төлбөл зохих төлбөрийн дүн (мөр 14-26)	30		

Төлбөрийн тооцоолол:

			Дебет	Кредит
Тайлангийн эхний үлдэгдэл	илүү	31		
	дутуу	32		
Тайланг хугацаанд ногдуулсан төлбөр (мөр 30)		33		
Тайланг хугацаанд дансаар төлсөн	Гүйцэтгэл	34		
	Өөрчлөлт /+,-/	35		
Татварын алба болон татвар төлөгч хоорондын тооцоогоор төлсөн		36		
Бусад татварын илүү төлөлтөөс суутган тооцсон		37		
Буцаан олгосон болон хүчингүй болгосон төлбөр		38		
Илүү төлөлтөөс бусад татварын өрөнд суутган тооцсон		39		
Тайлангийн эцсийн үлдэгдэл	илүү	40		
	дутуу	41		

Тайлан гаргасан:

Тайланг хүлээн авсан:

Дарга /Захирал/
тэмдэг

Татварын улсын байцаагч
тэмдэг

Ерөнхий нягтлан бодогч
тэмдэг

20 оны сарын –ны өдөр

Төлбөрийн тооцоолол:

			Дебет	Кредит
Тайлангийн эхний үлдэгдэл	илүү	13		
	дутуу	14		
Тайланг хугацаанд ногдуулсан төлбөр (мөр 12)			15	
Тайланг хугацаанд дансаар төлсөн	Гүйцэтгэл	16		
	Өөрчлөлт /+,-/	17		
Татварын алба болон татвар төлөгч хоорондын тооцоогоор төлсөн			18	
Бусад татварын илүү төлөлтөөс суутган тооцсон			19	
Буцаан олгосон болон хүчингүй болгосон төлбөр			20	
Илүү төлөлтөөс бусад татварын өрөнд суутган тооцсон			21	
Тайлангийн эцсийн үлдэгдэл	илүү	22		
	дутуу	23		

Тайлан гаргасан:

Тайланг хүлээн авсан:

Дарга /Захирал/
тэмдэг

Татварын улсын байцаагч
тэмдэг

Ерөнхий нягтлан бодогч
тэмдэг

20.... оны сарын –ны өдөр

**Агаарын бохирдлын төлбөрийн тайлангийн маягт /ТТ-24(1), 24(2), 24(3), 24(4)-ыг
нөхөх заавар**

1. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага (цаашид “төлбөр төлөгч” гэх) нь агаарын бохирдлын төлбөр, тооцоог энэхүү маягтаар хуульд заасан хугацаанд татварын албанд тайлагнах үүрэгтэй.

2. Татвар төлөгч нь төлбөрийн тайлан гаргахдаа Татварын ерөнхий газрын даргын 2010 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 379 дүгээр тушаалаар батлагдсан “Татварын тайлан гаргах, татварын албанд тайлан хүлээн авах журам”-ыг баримтална.

3. Төлбөр төлөгч нь Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан “Олборлосон түүхий нүүрс, үйлдвэрлэсэн болон импортолсон органик уусгагч, автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл, агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах хаягдалд”-д агаарын бохирдлын төлбөр (цаашид “төлбөр” гэх) ногдуулж, төлбөрийн тооцоог ТТ-24(1), 24(2), 24(3), 24(4) тайлангийн маягтуудаар хуульд заасан хугацаанд хийнэ.

4. Тайлангийн маягтын толгойн хэсэгт төлбөр төлөгчийн нийтлэг мэдээллийг тусгана.

5. **ТТ-24(1) тайлангийн маягтаар төлбөр төлөгчийн олборлосон түүхий нүүрсэнд ногдуулах төлбөрийн тооцооллыг тайлагнах** ба 1-р мөрөнд олборлосон түүхий нүүрсний хэмжээг, 4-р мөрөнд хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу **чөлөөлөгдөх боловсруулсан нүүрсний хэмжээг** тус тус тонноор илэрхийлж тусгана.

Олборлосон түүхий нүүрсэнд ногдуулсан төлбөрийн дүн /мөр 2/, чөлөөлөгдөх төлбөрийн дүн /мөр 3/-г тодорхойлохдоо маягтын 1, 4-р мөрөнд тусгасан олборлосон түүхий нүүрсний хэмжээ болон төлбөрөөс чөлөөлөгдөх боловсруулсан нүүрсний хэмжээг килограммд шилжүүлэн Засгийн газрын 2010 оны “Журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай” 273 дугаар тогтоолын 2-р хавсралт /Агаарын бохирдлын төлбөрийн хэмжээ/-ын 1-д заасны дагуу 1 төгрөгөөр тус тус үржүүлэх ба төлбөрийн дүнг мянган төгрөгөөр илэрхийлнэ.

Жишээ нь: Төлбөр төлөгч 1 сая тонн нүүрс олборлосон гэвэл 1000000 гэсэн дүнг 1-р мөрөнд тусгах ба олборлосон нүүрсэнд ногдуулах төлбөрийн дүнг тооцохдоо тонноор илэрхийлснийг килограммд шилжүүлэн гарсан дүнг 1 төгрөгөөр үржүүлж тодорхойлно.

$1\ 000\ 000\ \text{тн} \times 1000\ \text{кг} \times 1\ \text{төгрөг} = 1\ 000\ 000\ 000\ \text{төгрөг}$. 2-р мөрөнд энэ дүнг мянган төгрөг /1 000 000.0/-өөр тусгана.

Маягтын 6-р мөрөнд хуулийн 8.6-д заасныг үндэслэн Засгийн газраас баталсан журмын дагуу чөлөөлөгдөх, хөнгөлөгдөх төлбөрийн дүнг тусгана.

6. **Үйлдвэрлэсэн болон импортолсон органик уусгагчид ногдуулах агаарын бохирдлын төлбөрийг ТТ-24(2) маягтаар тайлагнана.**

Маягтын 1, 9-р мөрүүдэд үйлдвэрлэсэн болон импортолсон органик уусгагчийн хэмжээг тусгах ба 2-4, 10-12-р мөрүүдэд үйлдвэрлэсэн болон импортолсон органик уусгагчийг Засгийн газрын 2010 оны “Журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай” 273 дугаар тогтоолын 2-р хавсралт /Агаарын бохирдлын төлбөрийн хэмжээ/-ын 2-д заасны дагуу 3 зэрэглэлээр ангилан харуулна. Ингэхдээ тонноор илэрхийлж харуулна.

Органик уусгагчийн зэрэглэл тус бүрт ногдуулсан төлбөрийн дүнг маягтын 6-8, 14-16-р мөрүүдэд тусгах ба дүнг тооцохдоо органик уусгагч тус бүрийн хэмжээг килограммд шилжүүлэн Засгийн газрын 2010 оны “Журам батлах, төлбөрийн хэмжээ тогтоох тухай” 273 дугаар тогтоолын 2-р хавсралт /Агаарын бохирдлын төлбөрийн хэмжээ/-ын 2-д заасан I-III зэрэглэлийн холбогдох төлбөрийн дүнгээр үржүүлж тодорхойлно. Төлбөрийн дүнг мянган төгрөгөөр тусгана.

7. **ТТ-24(3) тайлангийн маягтаар Автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл (АТБӨЯХ)-д ногдуулах төлбөрийн тооцооллыг тайлагнана.**

Маягтын 1-р мөрөнд төлбөр төлөгчийн эзэмшилд байгаа АТБӨЯХ-ийн тоог тусгах ба 2-13-р мөрүүдэд “Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг

үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээ, хөдөлгүүрийн багтаамжаас хамааруулан ангилал тогтоох журам”-ын 2.1-д заасны дагуу ангилан харуулна.

АТБӨЯХ-д ногдуулсан төлбөрийн дүнг тодорхойлохдоо ангилал тус бүрийн АТБӨЯХ-ийн тоог хуулийн 7.3-д заасан А-Е ангиллын холбогдох төлбөрийн дүнгээр үржүүлж 15-20-р мөрөнд харуулах ба 14-р мөрөнд нийт ногдуулсан төлбөрийн дүнг тусгана.

Маягтын 3-р хэсэг буюу 22-25-р мөрөнд төлбөрөөс чөлөөлөгдөх АТБӨЯХ-ийн тоог хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3, 8.4-д заасны дагуу ангилан харуулна.

Чөлөөлөгдөх төлбөрийн дүн /мөр 26/нь хуулийн дагуу төлбөрөөс чөлөөлөгдөх АТБӨЯХ-д ногдуулах төлбөрийн нийлбэрээр тодорхойлогдоно.

8. Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрт ногдуулах төлбөрийн тооцооллыг ТТ-24(4) тайлангийн маягтаар тайлагнана.

Маягтын 1-р мөрөнд нийт суурин эх үүсвэрийн тоог тусгах ба 2,4,6,8-р мөрүүдэд агаарт гаргах хаягдал буюу агаар бохирдуулах бодисын хэмжээг Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т заасныг үндэслэн Засгийн газрын 2011 оны “Төлбөрийн хувь, хэмжээ тогтоох тухай” 92 дугаар тогтоолын хавсралт /Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах хаягдлын бохирдуулах бодисын төлбөрийн хувь, хэмжээ/-аар батлагдсан 4 зэргээр ангилан харуулах ба килограммаар илэрхийлнэ. Ногдуулсан төлбөрийн дүнг дээрх тогтоолд заасны дагуу зэрэг тус бүрийн холбогдох нэгжийн төлбөрийн дүнгээр үржүүлж тодорхойлно.

9. Тайлангийн “Төлбөрийн тооцоолол” хэсэгт тайлангийн эхний үлдэгдэл, тухайн тайлант хугацаанд ногдсон төлбөр, төлсөн төлбөр, буцаан олгосон болон хоорондын тооцоо гэх мэт ДТ-лэгдсэн дүнг тус тус тооцож, тайлангийн эцсийн илүү, дутуу үлдэгдлийн тооцоог хийж, баталгаажуулна. Агаарын бохирдлын төлбөрийг хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу төсөвт төлнө.

II. Албан татвар төлөлтийн тооцоолол

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлтийн нэр		Мөрийн дугаар	Дебет	Кредит
Оны эхний үлдэгдэл	Илүү	31		
	Дутуу	32		
Тайланг хугацаанд ногдуулсан албан татвар		33		
Тайлангийн хугацаанд төлсөн албан татвар		34		
Буцаан олгосон албан татвар		35		
Тайлангийн хугацааны эцсийн үлдэгдэл	Илүү $(32-31+33-34-35)<0$	36		
	Дутуу $(32-31+33-34-35)>0$	37		

Тайланг үнэн зөв гаргасан:

Тайланг хүлээн авсан:

Дарга /Захирал/:

Татварын улсын байцаагч:

ТЭМДЭГ

ТЭМДЭГ

Ерөнхий нягтлан бодогч:

20 оны сарын өдөр

20 оны сарын өдөр



Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн

албан татварын тайлангийн маягт "ХТТ-04"-ыг нөхөх заавар

1.Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшдэг аж ахуйн нэгжүүд нь нягтлан бодох бүртгэлээ үнэн зөв хөтлөн, "Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тайлан"-г энэхүү маягтаар хуульд заасан хугацаанд татварын албанд тайлагнах үүрэгтэй. Татварын тайлан гаргахдаа Татварын ерөнхий газрын даргын 2010 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн 379 дүгээр тушаалаар батлагдсан "Татварын тайлан гаргах, татварын албанд тайлан хүлээн авах журам"-ыг баримтална.

2. Тайлангийн маягт нь "А", "Б" гэсэн 2 үндсэн хэсэгтэй бөгөөд "А" хэсэгт тухайн татвар төлөгчийн талаарх "Нийтлэг мэдээлэл", "Б" хэсэгт "Албан татвар ногдуулалтын тооцоолол"-ийг тусгана.

3.Маягтын "А" хэсэг буюу "Нийтлэг мэдээлэл"-д авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл эзэмшдэг аж ахуйн нэгжийн нэр, регистр, ажлын байрны хаяг, харилцах утас, факс, эрхлэх үйл киллагаа, тайланд хамрагдах хугацааг бичнэ.

4.Тайлангийн "Б" хэсэг буюу "Албан татвар ногдуулалтын тооцоолол" нь "Албан татвар ногдуулалт" (1), "албан татвар төлөлтийн тооцоолол" (2), "албан татварт хамрагдсан авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн мэдээлэл" (3) гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

5."Б" хэсгийн "Албан татвар ногдуулалт" хэсэгт харъяалах Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас тогтоосон хэмжээгээр албан татварыг ногдуулж, тайлагнана.

-Ногдуулах албан татварыг Улсын Их Хурлаас баталсан хязгаарт багтаан Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоох ба татвар төлөгч нь АТБӨЯХ-ийн албан татварыг харъяалах орон нутгийн төсөвт төлнө.

-Албан татварыг суудлын автомашины хувьд цилиндрийн багтаамжаар, ачааны автомашин, чиргүүлийг даацаар нь тооцож ногдуулна.

6."Б" хэсгийн "Албан татвар төлөлтийн тооцоолол"-д тайлант хугацааны эхэнд байсан албан татварын илүү (31мөр), дутуу (32мөр), ногдуулсан албан татвар (33 мөр), тайлант хугацаанд төсөвт төлсөн албан татвар (34 мөр), тайлант хугацаанд буцаан олгосон албан татвар (35 мөр), тайлант хугацааны эцсийн илүү (36 мөр), дутуу (37 мөр)-г тайлагнана.

7."Б" хэсгийн "Албан татварт хамрагдсан автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн мэдээлэл"-д албан татварт хамрагдсан автомашин болон өөрөө явагч хэрэгслийн төрөл, машины нэр, марк, улсын дугаар, арлын дугаар, АТБӨЯХ, Агаарын бохирдлын төлбөрийн гэрчилгээний дугаар, суудлын автомашины цилиндрийн багтаамж, ачааны автомашины даац, албан татварын хувь хэмжээ, ногдох албан татварыг бөглөнө.

8.Аж ахуйн нэгж нь автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг тэнцүү хэмжээгээр улирал бүрийн сүүлчийн сарын 25-ны дотор багтаан төсөвт төлж, тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор татварын албанд ирүүлнэ. Иргэн нь авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг жилд нэг удаа тухайн жилийн 6 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө харъяалах татварын албанд төлнө.